



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2014 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 14


Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Америкийн Нэгдсэн Улсын Силикон вайлийд Монгол Улсын старт-ап компанийг бий болгох ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Ажлын удирдамжид тусгасан үе шаттай ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг 2014 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч /З.Энхболд/-д даалгасугай.

ДАРГА  Ц.ЖАДАМБАА

110185

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны  
газрын даргын 2014 оны 0/ сарын 11/ өдрийн  
11 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

УХА0514 5202965

Ажлын хэсгийн ахлагч:

З.Энхболд

Тус газрын дэд дарга

Ажлын хэсгийн нарийн бичиг:

Э.Бямбасүрэн

Тус газрын Мэдээллийн технологи, инновацийн хэлтсийн  
ахлах мэргэжилтэн

Ажлын хэсгийн гишүүд:

Р.Отгонтулга

Ерөнхий сайдын Мэдээллийн технологи хариуцсан зөвлөх

Б.Алтансүх

Тус газрын Төрийн захиргааны, удирдлага хамтын  
ажиллагааны газрын дарга

Ч.Лодойравсал

Монгол Улсын Их Сургуулийн Мэдээллийн технологийн  
сургуулийн захирал /тохиролцсоноор/

Б.Энхтөгс

Мэдээлэл холбооны технологийн сургуулийн Эрдэм  
шинжилгээ, инноваци эрхэлсэн дэд захирал  
/тохиролцсоноор/

Ч.Наранцэцэг

Мэдээллийн технологийн Үндэсний паркийн Стратеги,  
бизнес хөгжлийн газрын дарга /тохиролцсоноор/

Э.Алтанбагана

тус газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын  
мэргэжилтэн

С.Ганболд

Немо консалтинг ХХК-ийн захирал /тохиролцсоноор/

Д.Ганга

Шинэ эхлэх цэг Төрийн бус байгууллагын гүйцэтгэх  
захирал /тохиролцсоноор/

С.Эрдэнэбат

Эйч Ди Эс Консалтинг ХХК-ийн захирал /тохиролцсоноор/

С.Наранхүү

Хилийн чанадад амьдарч буй Монгол улсын иргэдийн эрх  
ашгийг хамгаалах хамтран ажиллах зөвлөлийн Удирдах  
зөвлөлийн гишүүн /тохиролцсоноор/

Ц.Эрдэнэбат

Гүүмэл ХХК-ийн захирал /тохиролцсоноор/

Б.Энхтүвшин

Н.Баттулга

А.Ууганбаяр

Ч.Чимэддорж

Оюу толгой ХХК-ийн Бизнесийн шинжээч /тохиролцсоноор/  
ITZONE компаний ерөнхий захирал /тохиролцсоноор/  
Интер-Актив ХХК-ны ерөнхий захирал /тохиролцсоноор/  
Интер-Актив Би Ай ХХК-ны ерөнхий захирал  
/тохиролцсоноор/

Б.Ганбат

Б.Ананд

Саммит ХХК-ны ерөнхий захирал /тохиролцсоноор/  
Слайд ХХК /тохиролцсоноор/

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны  
газрын даргын 2014 оны 01 сарын 14 өдрийн  
14 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Зорилго:

Монголын Мэдээллийн технологийн салбараас олон улсын түвшинд өрсөлдөх боломжтой шилдэг санааг шалгаруулан АНУ-ын Силикон вайлийд старт-ап компани гаргах

Зорилтууд:

1. Силикон вайлийд старт-ап компани гаргахад тавигдах шаардлагыг судалж, шийдлийг боловсруулах
2. Шилдэг санааг шалгаруулах
3. Шилдэг багийг бэлтгэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

Силикон Вайлийд Монгол старт-ап компани гаргах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

I үе шат:

- 1.1 Ямар шалгуурыг хангасан байх ёстой судалгааны ажил хийнэ.
- 1.2 Судалгааны үр дүнд тулгуурлан шийдэл, удирдамжийг боловсруулна.
- 1.3 Хэрэгжүүлэх төлөвлөгөө болон холбогдох төслийг боловсруулна.
- 1.4 Төсвийн тооцоо хийнэ.

II үе шат:

- 2.1 Шилдэг санааны шалгаруулалтыг зохион байгуулна.

III үе шат:

- 3.1 Үндэсний баг бэлтгэх ТВ реалити шоу зохион байгуулах
- 3.2 Шинжлэх ухаан технологийн сан, Инновацийн сан, хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах
- 3.3 Цаашид санаагаа бүтээл болгох сонирхолтой иргэн, ААН болон хөрөнгө оруулагч нарыг холбосон /startup.com/ сайтыг ажиллуулж эхлэх

Ажлын хэсгийн ажиллах дэг:

1. Ажлын хэсэг нь 7 хоногт 1-2 удаа хуралдана.
2. Ажлын хэсгийн гишүүн нь хуралд заавал ирэх ба ирэх боломжгүй тохиолдолд төлөөлөх хүнийг илгээж, мэдээллийг гүйцэд авч, хэлэлцэх асуудлаар өөрийн саналыг солилцоно.
3. Хурлын төгсгөлд хурлын тэмдэглэлд заавал гарын үсэг зурж баталгаажуулна.
4. Ажлын хэсгийн гишүүд нь судалгаа, төсөл, төсвийн тооцоо, зохион байгуулалт, сурталчилгаа гэх мэт чиглэл чиглэлээр баг болон ажиллана.